


МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Г Т

Төслийн удирдах хорооны
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжих төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1.3, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3”, “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4”, “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төслийд хэрэгжилтийг хангах үүрэг бүхий төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.
2. Төслийн удирдах хорооны үйл ажиллагааг “Засгийн газрын гадаад зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжих төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-д заасан эрх, үүрэг болон төслийг хэрэгжүүлэх буцалтгуй тусlamж, зээлийн хэлэлцээрээр тогтоосон хэм хэмжээний хүрээнд зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Удирдах хорооны дарга (албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Ганчимэг)-д үүрэг болгосугай.
3. Төслийн удирдах хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /Ц.Атармаа/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын “Удирдах хороо байгуулах тухай” 2012 оны 394 дүгээр тушаал, “Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 2013 оны 373 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal
080401

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 30/өдрийн
118 дугаар тушаалын хавсралт

ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга:

“Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3,4,5” төслийн ажилтан

Гишүүд:

“Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3,4,5” төслийн удирдагч;

Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга;

Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга;

Эрүүл мэнд, спортын яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга;

Эрүүл мэнд, спортын яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга;

Эрүүл мэнд, спортын яамны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга;

Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын гадаад хамтын ажиллагааны бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн;

Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга;

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн;

Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн зохицуулагч;

Нийгмийн даатгалын өрөнхий газрын дарга;
Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал;

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал;

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч дарга (зөвшилцсөнөөр);

Мэргэжлийн хяналтын өрөнхий газрын дарга (зөвшилцсөнөөр);

Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр);

Монголын эмнэлгүүдийн холбооны төлөөлөл (зөвшилцсөнөөр);

Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбооны захирал (зөвшилцсөнөөр)